

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 06 дугаар сарын 15

Багануур дүүрэг

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Зорилт	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Гүйцэтгэл хувь	Үнэлгээний хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ - ӨРХ БҮРД							
1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ.							
1.1.1.4. Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ.	1.5. “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ.	1.5.1. ХЕТ, инженерийн дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлэн хүлээн авах	БХБЯ, БҮТП ОНӨТҮГ, Мон-Энержи Консалт ХХК	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	93%	
		<p>“Мон-Энержи Консалт” ХХК нь цахилгааны горим ачааллын тооцоог Эрчим хүчний яамны “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иар гүйцэтгүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/16 дугаартай албан бичгээр хүлээн авсан. Ингэснээр цахилгаан хангамжийн төлөвлөлтийн зураг төсөл бэлэн болсон. Зураг төслийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг авах асуудлыг Газрын дарга Эрчим хүчний яамны сайдтай биечлэн уулзаж шийдвэрлэсэн. “Мон-Энержи Консалт” ХХК нь Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн батлагдсан төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01 дугаартай актаар “Барилга хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.</p> <p>2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ЭХЯ-наас техникийн нөхцөлийг хүлээн авч, БХБЯ болон Мон-энержи Консалт ХХК-д хүлээлгэн өгсөн. “Мон-Энержи Консалт” ХХК-ийн Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл магадлангаар хянагдаж баталгаажсан. Барилга хөгжлийн төвийн нэгдсэн дүгнэлт хүлээгдэж байна.</p>					
		1.5.2. БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг боловсруулж дээд шатны байгууллагуудад хүргүүлэх	БҮТП ОНӨТҮГ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	50%	
		- Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч, төлөөлөгчдийн 2020 оны 02 дугаар улирлын хурлаар Парк хөгжүүлэх сан байгуулах, паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалттай холбогдсон					

		<p>асуудлыг хэлэлцүүлэх саналыг Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны 14 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тодотгол хийх гэж байгаатай холбогдуулан Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газарт Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн саналыг, салбарын өнөөгийн байдал, 2019 оны ажлын гүйцэтгэл, ТЭЗҮ, ТЭЗҮС, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний тайлбар зэрэг шаардлагатай бусад материалын хамт “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 24 дугаартай албан бичгээр хүргүүлэв. - БҮТП-ийн дэд бүтэц, нийтийн барилга байгууламж болон ногоон байгууламжуудыг байгуулах хөрөнгө оруулалтын төслийг 2020-2025 он хүртэлх хугацаагаар нарийвчлан тооцон гаргаж, 2021 онд хэрэгжүүлэх төслүүдийн саналуудыг салбарын яамдуудад 2020.01.24-ний өдрийн 15, 02.07-ны өдрийн 24, 04.22-ны өдрийн 73, 04.27-ны өдрийн 75, 06.03-ны өдрийн 100, 102 дугаартай албан бичгүүдээр тус тус уламжилсан. 					
	<p>1.5.3. Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>		<p>БҮТП ОНӨТҮГ</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>100%</p>	<p>65%</p>	
		<ol style="list-style-type: none"> 1. 2020 онд Олон улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрт тусгуулах инновацийн 2 төслийн саналыг боловсруулж 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаартай албан бичгээр хүргүүлэв. 2. Дэвшилтэд техник, технологийн материалуудыг төрөлжүүлэн ангилж, сэдэв зүйлийн заагчийн жагсаалт, ашиглах зааврыг бэлтгэн мэдээллийн санг байгуулсан. 3. Паркийн хөгжлийн эхний дунд хугацааны стратеги төлөвлөгөө, CROSS SWOT шинжилгээнд дүгнэлт хийж, Паркийн хөгжлийн II дунд хугацааны стратеги төлөвлөгөөг гарган, ЗГ-ын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтын дагуу 1 дүгээр бүлгийн төслийг боловсруулан удирдлагаар хянуулсан. 4. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмын 3.4 / Паркийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа явуулах нэгж, технологийн инкубатор төв байгуулах/ заалтын дагуу ХААИС, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, ШУТИС, ШАУИС-иудтай 2019 онд байгуулсан хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр хүргүүлж, ЗГ-ын 30 тогтоолын хэрэгжилтийг ханган хамтран дүгнэх ажлыг цахимаар зохион байгуулав. <ol style="list-style-type: none"> a. 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр МУИС-ийн 10 төлөөлөгч эрдэмтэн багш нарыг хүлээн авч, хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөөг баталж, Багануур ХК-ийн үйл ажиллагаатай танилцуулав. b. Эхний хагас жилд хийгдэх төлөвлөгөөт үйл ажиллагаанууд корона вирусын цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. 					

	<p>5. Паркуудийн үйл ажиллагааг эрчимжүүлэх томоохон ажлуудыг зохион байгуулж, хамтран ажиллах зорилготой Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газрын дарга Б.Мөнх-Оргилд байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн үр дүн, цаашдын зорилго, зорилтууд мөн тулгамдсан асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>6. Паркийн бүсүүдэд хөрөнгө оруулах төслүүдийн саналыг хүлээн авах, зөвлөгөө өгөх, мөн Улаанбаатар хотод зохион байгуулагддаг техник технологийн үзэсгэлэн яармаг, хөрөнгө оруулагчдын уулзалт, зөвлөгөөнүүдэд оролцож, өөрийн Паркийн үйл ажиллагааг сурталчлан оролцох зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулан ажилласан. 2020 оны 03 сарын 04-ний өдөр цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгон үйлдвэрлэх технологийн мэдээллийг “Эко Тайхи” ХХК-ийн менежер Ш.Болдсайхан-аас авч, хот хаягдлаар бордоо үйлдвэрлэдэг технологитой хоршуулах боломжийн талаар санал солилцов.</p> <p>7. БҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, үндсэн чиглэлийн хөрөнгө оруулалтын төслүүдийг хүлээн авах, бүтээн байгуулалтыг эхлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор БХБЯ, ЭХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ-дад хамтран ажиллах тодорхой саналуудыг хүргүүлэн ажиллаж байна.</p>	
Дундаж хувь		69,3%

БИЕЛЭЛТ ХЯНАСАН
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lasurit

Б.НОМИНЗУЛ